



МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
ТОГТООЛ

2021 оны 02 сарын 05 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.3 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Сонгуулийн ерөнхий хорооны 2020 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 11 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Мэдээллийн технологийн багийн гишүүн, даамлын сургалт явуулах, гэрчилгээ олгох журам”-ын нэгдүгээр бүлэгт доор дурдсан агуулгатай 1.3 дахь хэсгийг нэмсүгэй.

“1.3. Энэхүү журмыг хэрэгжүүлэх ажилд тухайн шатны сонгуулийн хороо, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар шаардлагатай дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.”

2. Мөн журмын 2.3 дахь хэсгийн “10” гэснийг “15” гэж, 3.1. дэх хэсгийн “Төв” гэснийг “Төвийн захирал” гэж тус тус өөрчилсүгэй.

3. Мөн журмын 3.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

“3.3. Төвийн сургалтад хамрагдсан багийн гишүүд, даамал нь сонгуулийн автоматжуулсан системийн үйл ажиллагааг танилцуулах сургалтыг Төвөөс баталсан хуваарь, заавар, зөвлөмжийн дагуу зохион байгуулж болно.”

ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



П.ДЭЛГЭРНАРАН

Д.ДАВАА-ОЧИР

00000018